



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Техник ашиглалтын дүрэм батлах тухай

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, Инженерийн байгууламж, шугам сүлжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ус хангамж, ариутгах татуургын системийн техник ашиглалтын дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/-т, техник ашиглалтын дүрмийг нийтэд сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /Ж.Батсуурь/-д тус тус даалгасугай.



Х.БАДЕЛХАН